

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/3/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшсүрэн Утас: 51-261740 Цахим хаяг: tegshsurenb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.6 Худалдан авах, ажиллагааны гүйцэтгэл	20
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Харьяа байгууллагууд.....	24
5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	24
5.3.1 Төлбөрийн акт	24
5.3.2 Албан шаардлага	25
5.3.3 Зөвлөмж.....	25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГГ	Гаалийн газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГЕГД	Гаалийн ерөнхий газрын дарга
ГХ	Гаалийн хороо
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УХШИГГ	Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА П.ДЭЛГЭРНАРАН ТАНАА

2026.03.25 № 304
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гаалийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Засгийн газрын 249 дүгээр тогтоолоор 2024 оны хөрөнгө оруулалтын 10.7 тэрбум төгрөгийг барьцаа дансанд байршуулсан Гаалийн шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй Гашуунсухайт хилийн боомтын импорт талд суурилуулсан рентген төхөөрөмжийн 5.5 тэрбум төгрөг, Замын-Үүд боомтын экспорт талд суурилуулсан рентген төхөөрөмжийн үлдэгдэл 60.0 хувь 8.7 тэрбум төгрөг, “Харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдыг зөөвөрлөх зориулалт бүхий тээврийн хэрэгсэл” төсөл арга хэмжээний хүрээнд 11 хүний суудалтай бага оврын автобус 6 ширхэг 0.9 тэрбум төгрөг, Алтанбулаг, Боршоо боомтуудад суурилуулсан Ариутгалын төхөөрөмжийн үлдэгдэл гүйцэтгэл 1.1 тэрбум төгрөгийг тус тус гүйцэтгэлээр олгосон байна.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны А-1/1883 тоот албан бичгийн дагуу 5 нэр төрлийн 0.5 тэрбум төгрөгийн балансын үнэтэй 8 тээврийн хэрэгслийн үнийг нийт 0.3 тэрбум төгрөгөөр бууруулан, 0.2 тэрбум төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Гаалийн байгууллага нь 7,777.8 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 6,712.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 86.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унасан нь уул уурхайн салбарын өсөлтийг сааруулсан, үүний улмаас эдийн засгийн идэвхжил суларч, импорт буурснаас шалтгаалсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоог 9 хувь хүртэл бууруулах чиглэлийн дагуу Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн "Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 52 дугаар тогтоолоор Гаалийн ерөнхий газрын орон тооны дээд хязгаарыг 127 байхаар өөрчилж баталсан. Мөн гаалийн албаны орон тоог 2466 байсныг 2244 болгон 222 орон тоогоор бууруулахаар холбогдох баримт бичгийг боловсруулсан байна.

Гүйцэтгэлээр гаалийн байгууллага 2017 буюу төрийн тусгай албан хаагч 407, төрийн үйлчилгээний ажилтан 42, нийт 449 албан хаагч дутуу ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,812,561.3	18,993,900.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,762,269.2	716,358.6
33	АВЛАГА	1,162,182.1	1,696,669.2
34	УРЬДЧИЛГАА	11,609.1	596,639.3
35	БАРАА МАТЕРИАЛ	10,528,432.6	10,148,174.1
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	15,348,068.2	5,836,059.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	285,387,210.0	371,085,025.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	285,387,210.0	371,085,025.4
39200	Биет хөрөнгө	275,067,776.5	361,337,963.4
39300	Биет бус хөрөнгө	10,319,433.5	9,747,062.1
3	ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	325,199,771.3	390,078,926.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,971,118.1	4,016,500.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,971,118.1	4,016,500.7
41300	Өглөг	11,971,118.1	4,016,500.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	313,228,653.2	386,062,425.4
51	Засгийн газрын хувь оролцоо	313,228,653.2	386,062,425.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	72,665,451.2	72,833,827.2
51200	Хуримтлагдсан үр дүн	233,781,519.9	306,507,846.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,781,682.1	6,720,751.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	325,199,771.3	390,078,926.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	271,374,331.1	239,423,727.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,563,723.4	106,052,703.1
120	Нийтлэг татварын бус орлого	127,563,723.4	106,052,703.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,810,607.6	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	142,733,278.0	166,367,726.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,733,278.0	166,367,726.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	121,826,451.2	147,667,521.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,256,045.1	81,313,604.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,948,725.3	10,513,129.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,232,820.6	6,533,519.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,805,330.2	1,784,668.2
2105	Нормативт зардал	2,367,386.8	2,175,739.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,539,404.9	1,112,960.9
2107	Томилолт, зочны зардал	622,838.7	305,457.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,151,441.0	3,721,790.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,902,458.4	40,206,651.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,906,826.8	18,700,204.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	128,641,053.0	73,056,001.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,755,124.3	335,773.2
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(10,755,124.3)	(335,773.2)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	117,885,928.7	72,720,228.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,646,284.8	6,781,682.1	115,960,549.4	195,388,516.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,764.0)	-	(64,958.2)	(69,722.2)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,641,520.8	6,781,682.1	115,895,591.2	195,318,794.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	23,930.4	-	-	(23,930.4)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	117,885,928.7	117,885,928.7
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,665,451.2	6,781,682.1	233,781,519.9	313,228,653.2
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	168,376.0	-	(54,831.7)	113,544.3
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,833,827.2	6,781,682.1	233,726,688.2	313,342,197.4
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(60,930.3)	60,930.3	-
14	Тайлант үеийн үр дүн	-	-	72,256,054.5	72,256,054.5
15	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,833,827.2	6,720,751.8	306,043,673.0	385,598,251.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	161,381,625.3	137,675,922.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,991,087.9	137,675,922.9
120	Нийтлэг татварын бус орлого	16,991,087.9	3,609,948.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	144,390,537.3	134,065,974.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	130,794,049.4	127,065,323.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,794,049.4	127,065,323.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	107,589,036.3	107,187,779.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	71,915,485.4	81,349,648.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,220,018.1	10,437,179.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,277,566.5	6,581,604.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,273,006.0	1,219,228.3
2105	Нормативт зардал	2,571,124.6	1,261,281.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,358,621.1	1,338,547.6
2107	Томилолт, зочны зардал	623,197.3	305,457.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,941,663.0	3,481,134.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,408,354.3	1,213,719.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,205,013.1	19,887,544.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	30,584,575.8	10,610,599.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	37,252,750.4	22,656,509.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,252,750.4	22,656,509.7
2200	Дотоод эх үүсвэрээр	37,252,750.4	22,656,509.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(37,252,750.4)	(22,656,509.7)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(6,665,174.6)	(12,045,910.6)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,427,443.8	12,762,269.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,762,269.2	716,358.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	139,982,337,568.30	120,563,136,977.84	19,419,200,590.46	86.1
12	Татварын бус орлого	139,982,337,568.30	120,563,136,977.84	19,419,200,590.46	86.1
120	Нийтлэг татварын бус орлого	4,390,707,200.00	3,333,254,173.53	1,057,453,026.47	75.9
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого / туслах/	4,390,707,200.00	3,333,254,173.53	1,057,453,026.47	75.9
122	Тусламжийн орлого	135,729,900,700.00	117,229,882,804.31	18,500,017,895.69	86.4
122005	Төсвөөс санхүүжих	135,591,630,368.30	117,229,882,804.31	18,361,747,563.99	86.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,591,630,368.30	120,563,136,977.84	15,028,493,390.46	88.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,021,307,900.00	110,602,107,309.54	19,419,200,590.46	85.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	126,630,130,100.00	107,341,940,636.43	19,288,189,463.57	84.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,286,622,400.00	80,718,730,850.96	10,567,891,549.04	88.4
210101	Үндсэн цалин	38,870,588,900.00	34,379,416,603.83	4,491,172,296.17	88.5
210102	Нэмэгдэл	27,909,539,800.00	24,265,346,774.82	3,644,193,025.18	86.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,097,453,600.00	13,871,145,650.00	2,226,307,950.00	86.2
210104	Урамшуулал	8,409,040,100.00	8,202,821,822.31	206,218,277.69	97.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,907,441,500.00	10,358,808,062.47	1,548,633,437.53	87.0
210201	Тэтгэврийн даатгал	7,274,150,600.00	6,783,461,994.10	490,688,605.90	93.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,784,416,400.00	1,299,505,407.70	484,910,992.30	72.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	483,120,800.00	412,782,599.45	70,338,200.55	85.4
210204	Ажилгүйдлийн даатгал	474,847,100.00	373,515,133.14	101,331,966.86	78.7
210205	Эрүүл мэндийн даатгал	1,890,906,600.00	1,489,542,928.08	401,363,671.92	78.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,869,433,200.00	6,581,604,280.05	1,287,828,919.95	83.6
210301	Гэрэл, цахилгаан	3,565,611,200.00	2,753,053,447.63	812,557,752.37	77.2
210302	Түлш, халаалт	3,515,024,600.00	3,337,757,771.90	177,266,828.10	95.0
210303	Цэвэр, бохир ус	586,193,800.00	389,367,310.47	196,826,489.53	66.4
210304	Байрны түрээс	202,603,600.00	101,425,750.05	101,177,849.95	50.1
2104	Хангамж, бараа материалын зардал	1,603,350,000.00	1,224,593,485.49	378,756,514.51	76.4
210401	Бичиг хэрэг	197,032,500.00	145,583,625.00	51,448,875.00	73.9
210402	Тээвэр, шатахуун	916,785,400.00	714,179,411.00	202,605,989.00	77.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	104,567,800.00	82,151,823.32	22,415,976.68	78.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон	78,826,300.00	25,265,728.00	53,560,572.00	32.1

Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	мэрэгчдийн устгал, ариутгал				
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	306,138,000.00	257,412,898.17	48,725,101.83	84.1
2105	Нормативт зардал	1,961,940,900.00	1,261,281,031.57	700,659,868.43	64.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	777,977,300.00	325,591,393.57	452,385,906.43	41.9
210502	Хоол, хүнс	198,522,400.00	169,325,738.00	29,196,662.00	85.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	985,441,200.00	766,363,900.00	219,077,300.00	77.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,922,053,000.00	3,190,122,380.54	1,731,930,619.46	64.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	734,758,600.00	642,280,069.00	92,478,531.00	87.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,903,700.00	29,781,706.00	288,121,994.00	9.4
210604	Урсгал засвар	3,869,390,700.00	2,518,060,605.54	1,351,330,094.46	65.1
2107	Томилолт, зочны зардал	325,757,700.00	237,497,990.00	88,259,710.00	72.9
210701	Гадаад албан томилолт	118,433,700.00	101,113,990.00	17,319,710.00	85.4
210702	Дотоод албан томилолт	207,324,000.00	136,384,000.00	70,940,000.00	65.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,318,650,200.00	3,631,143,318.35	2,687,506,881.65	57.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,857,805,600.00	2,493,801,677.63	364,003,922.37	87.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	33,253,800.00	19,141,000.00	14,112,800.00	57.6
210803	Даатгалын үйлчилгээ	433,622,400.00	382,162,031.72	51,460,368.28	88.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27,053,900.00	21,720,164.00	5,333,736.00	80.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	3,650,200.00	2,494,500.00	1,155,700.00	68.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,938,633,000.00	87,690,950.00	1,850,942,050.00	4.5
210807	Газрын төлбөр	27,458,100.00	24,655,787.00	2,802,313.00	89.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	997,173,200.00	599,477,208.00	397,695,992.00	60.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	434,881,200.00	138,159,237.00	296,721,963.00	31.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	302,381,200.00	53,487,117.00	248,894,083.00	17.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	132,500,000.00	84,672,120.00	47,827,880.00	63.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,391,177,800.00	3,260,166,673.11	131,011,126.89	96.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	120,088,700.00	119,193,659.02	895,040.98	99.3

Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	120,088,700.00	119,193,659.02	895,040.98	99.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,271,089,100.00	3,140,973,014.09	130,116,085.91	96.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,985,268,700.00	1,906,325,058.17	78,943,641.83	96.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,241,595,400.00	1,190,586,955.92	51,008,444.08	95.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	44,225,000.00	44,061,000.00	164,000.00	99.6
8	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,961,029,668.30	9,961,029,668.30	0.00	100.0
9	Тоног төхөөрөмж	9,961,029,668.30	9,961,029,668.30	0.00	100.0
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(4,001,200.00)	4,001,200.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,792,200.00	(5,792,200.00)	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,791,000.00	(1,791,000.00)	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,244	2,017	227	89.9
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	2,244	2,017	227	89.9
620001	Удирдах ажилтан	44	44	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1,673	1,481	192	88.5
620003	Үйлчлэх ажилтан	527	492	35	93.4
620004	Гэрээт ажилтан	-	-	0	0.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2,244	2,017	227	89.9
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	1,717	1,525	192	88.8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	527	492	35	93.4

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		1,594,290,654.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,594,290,654.00
122	Тусламжийн орлого		1,594,290,654.00
1221	Хандив тусламж /дотоод/		1,594,290,654.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,594,290,654.00
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		64,329,900.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		735,309,914.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		38,899,300.00

Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		755,751,540.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		854,764,854.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ		854,764,854.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		854,764,854.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		630,917,438.15
210102	Нэмэгдэл		182,672,573.92
210104	Урамшуулал		448,244,864.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		78,371,246.07
210201	Тэтгэврийн даатгал		54,917,646.51
210202	Тэтгэмжийн даатгал		5,773,944.50
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,063,394.16
210204	Ажилгүйдлийн даатгал		2,586,453.74
210205	Эрүүл мэндийн даатгал		11,029,807.16
2104	Хангамж, бараа материалын зардал		3,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		10,325,773.00
210602	Тавилга		8,700,000.00
210604	Урсгал засвар		1,625,773.00
2107	Томилолт, зочны зардал		67,959,867.00
210701	Гадаад албан томилолт		24,175,767.00
210702	Дотоод албан томилолт		43,784,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,757,530.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,757,530.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		57,133,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		54,533,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		739,525,799.78
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(739,525,799.78)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(739,525,799.78)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гаалийн байгууллага нь “Гаалийн байгууллагын шударга байдлыг дээшлүүлэх” эрхэм зорилго, ил тод байдлыг хангасан, инновацыг дэмжсэн, иж бүрэн түншлэл бүхий байгууллага болох алсын харааг дэвшүүлэн, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах чиг үүрэгтэй Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Гаалийн ерөнхий газар нь эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах;
- Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх;
- Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх;
- Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д *“төсвийн төвлөрүүлэн захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг* гэж заасны дагуу Засгийн газрын 2026 оны 06 дугаар тогтоолоор томилогдсон Гаалийн ерөнхий газрын дарга П.Дэлгэрнараран нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Тайлант онд гаалийн ерөнхий газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 22 гаалийн газар, хороодын санхүүгийн тайланг нэгтгэжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Гаалийн байгууллага нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын 9 гэрээ, конвенц, Гаалийн тухай хууль, Гаалийн татвар, гаалийн тарифын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох Улсын Их Хурлын тогтоол, Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудын хүрээнд үндсэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавар;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан;
- Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 дүгээр тушаалаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан;

Гаалийн ерөнхий газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Гаалийн байгууллагын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/190 тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ыг мөрдөн ажилладаг ба тайлант онд хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/272 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон боловч холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлттэй уялдуулан сайжруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,879.1 сая төгрөгөөр буюу 19.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Мөнгөн хөрөнгө	12,762,269.2	716,358.6	(12,045,910.6)
Авлага	1,162,182.1	1,696,669.2	534,487.1
Урьдчилгаа	11,609.1	596,639.3	585,030.2
Бараа материал	10,528,432.6	10,148,174.1	(380,258.4)
Бусад эргэлтийн хөрөнгө	15,348,068.2	5,836,059.5	(9,512,008.7)
Үндсэн хөрөнгө	285,387,210.0	371,085,025.4	85,697,815.4
Нийт хөрөнгө	325,199,771.3	390,078,926.1	64,879,154.9
Богино хугацаат өр төлбөр	11,971,118.1	4,016,500.7	11,971,118.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	313,228,653.2	386,062,425.4	313,228,653.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	325,199,771.3	390,078,926.1	64,879,154.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 716.3 сая төгрөг болж, өмнөх оноос 12,045.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	20.7	-	(20.7)
Банканд байгаа бэлэн мөнгө	12,762,248.5	716,358.6	(12,045,889.9)
Төрийн сангийн харилцах	12,756,456.3	714,567.6	(12,041,888.7)
Арилжааны банк дахь харилцах	5,792.2	1,791.0	(4,001.2)
Дүн	12,762,269.2	716,358.6	(12,045,910.6)

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад Засгийн газрын 2024 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 249 дүгээр тогтоолын дагуу 10,734.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон нь голлон нөлөөлсөн бол дансны үлдэгдэлд хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн баталгаат хугацааны барьцаа 716.4 сая төгрөг, 2025.12.31-нд хийсэн арилжааны банкны орлогын 1.8 сая төгрөгийн дүн бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Батлагдаагүй орон тоонд ажилтан авч ажиллуулан 9.3 сая төгрөгийн цалин олгосон. /Орхон аймаг дахь ГГ/
- Алба хаагчдын 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллын санхүүжилт 12 сарын 31-нд нээгдэж гүйлгээ хийгдсэнтэй холбоотой 0.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэн. /Орхон аймаг дахь ГГ/
- Ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчдад болон албан тушаалаасаа чөлөөлөгдсөн албан хаагчид ээлжийн амралтын цалинг олгоходоо хоногийг илүү тооцож, 3.9 сая төгрөг олгосон. /Завхан аймаг дахь ГГ/
- Суурьшлын бус газар нутагт зохион байгуулсан сургалтад бэлэг дурсгал, бензиний зардал гаргаж, 2.3 сая төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан. /Завхан аймаг дахь ГГ/
- Түр орлон гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг илүү олгосон./Дорнод аймаг дахь ГГ/
- 5 жилийн тэтгэмжид албан татвар суутгаагүй. /Дорнод аймаг дахь ГГ/
- Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй, Монгол бичгийн хаяг хийлгэхэд 14.1 сая төгрөгийг зарцуулсан. /ГЕГ-ын Үйлчилгээ, аж ахуйн алба/
- Тайлант онд ажил байдлын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байгаа албан хаагч нарт 45.1 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон байна. /ГЕГ-ын Үйлчилгээ, аж ахуйн алба/
- Хөвсгөл аймгийн гаалийн хэлтсийн 8 айлын орон сууцны барилгын ажлыг 2014 онд гүйцэтгүүлэх гэрээг Сант өндөр ХХК-тай байгуулж 10.0 сая төгрөгийн барьцаа байршуулсан, тайлант онд харилцагч талаас нэхэмжлэх шаардлагагүй гэсэн тооцоо ирүүлсэн боловч тус барьцааны үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй./ГЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс/
- Баримтын бүрдэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээг бүртгэсэн. /Сэлэнгэ аймаг дахь ГГ/

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,696.7 сая төгрөг болж, өмнөх оноос 534.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	390.0	5,280.1	4,890.1
Татаас, санхүүжилтийн авлага	710,296.4	1,177,686.2	467,389.8
Байгууллагаас авах авлага	450,559.1	512,468.3	61,909.1
Хувь хүмүүсээс авах авлага	936.6	1,234.6	298.1
Дүн	1,162,182.1	1,696,669.2	534,487.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлагын өсөлтөд Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 224 дүгээр тушаалаар Гаалийн байгууллагын 2024 оны төсвийн жилийн үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос хуваарилсан боловч тайлант онд эрх нээгдээгүйгээс шалтгаалан зарцуулаагүй байсан 710.0 сая төгрөг, ахмадын сангийн 467.7 сая төгрөг, нийт 1,177.7 сая төгрөгийг жилийн эцэст улсын төсөвт төвлөрүүлж, тооцоо нийлж, татаас санхүүжилтийн авлагаар, Дархан-Уул аймаг дахь ГГ-ын конторын барилгын засварын ажлын гүйцэтгэл 485.2 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагатай тооцоо нийлж авлагаар бүртгэсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 596.6 сая төгрөг болж, өмнөх оноос 585.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Гаалийн ерөнхий газрын Үйлчилгээ аж ахуйн алба 1 жилийн хугацаатай лицензийн төлбөрийн дараа ногдол зардлыг урьдчилж гарсан зардалд бүртгэж тайлагнаснаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	11,609.1	596,639.3	585,030.2
Дүн	11,609.1	596,639.3	585,030.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 10,148.2 сая төгрөг болж, өмнөх оноос 380.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	1,232,828.1	1,378,297.0	145,468.9
Эм боох материал	110,740.2	107,380.4	(3,359.8)
Бэлэн бүтээгдэхүүн	3,366,016.3	2,450,919.1	(915,097.2)
Хангамжийн материал	5,645,782.0	5,976,032.7	330,250.6
Бичиг хэргийн материал	104,121.6	63,788.9	(40,332.7)
Аж ахуйн материал	2,496,553.7	3,021,699.0	525,145.3
Сэлбэг хэрэгсэл	90,843.0	68,450.3	(22,392.7)
Түлш, шатах тослох материал	161,485.9	156,005.9	(5,480.1)
Барилгын засварын материал	34,699.4	34,035.8	(663.6)
Хүнсний материал	9,248.4	1,228.2	(8,020.2)
Бусад хангамжийн материал	2,748,830.0	2,630,824.5	(118,005.5)
Мал амьтад	173,066.0	235,545.0	62,479.0
Дүн	16,174,214.6	16,124,206.8	(50,007.80)

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Бараа материал дансны бууралтад гаалийн ерөнхий газрын бэлэн бүтээгдэхүүн 915.1 сая төгрөг, Өмнөговь Гашуунсухайт 21,362.0 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн бол Увс аймаг дахь гаалийн хорооны аж ахуйн материалын 417.9 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалан өссөн байна.

Тайлант онд Гаалийн ерөнхий газрын харьяа газар, хороод нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор нийт 6,214.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 3,964.4 сая төгрөгийн материал шилжүүлэн авч, 52.5 сая төгрөгийн мал амьтадын нас дэвшилт болон бараа материал дансны ангиллыг шинэчлэн, 5,185.9 сая төгрөгийн бараа материал зарцуулж, 4,899.5 сая төгрөгийн материал шилжүүлж, 526.5 сая төгрөгийн материал акталсан байна.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 5,836.1 сая төгрөг болж, өмнөх оноос 9,512.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	15,348,068.2	5,836,059.5	(9,512,008.7)
Дүн	15,348,068.2	5,836,059.5	(9,512,008.7)

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Гаалийн ерөнхий газар нь тайлант хугацаанд бусад эргэлтийн хөрөнгөнд 23,123.3 сая төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгө, 23.1 сая төгрөгийн маягт, 4,956.8 сая төгрөгийн аж ахуйн материал, 927.3 сая төгрөгийн дүрэмт хувцас, нийт 29,030.4 сая төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгө болон бараа материал бүртгэж, 32,635.3 сая төгрөгийн бусад эргэлтийн хөрөнгийг 15 гаалийн хороодод ГЕГ-ын даргын А/272, А/182, А/183, А/271, А/293, А/294, А/323, А/324, А/325, А/385, А/386, А/390, А/391, А/486 дугаар тушаалуудыг үндэслэн шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 371,085.0 сая төгрөг болж, өмнөх оноос 85,697.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	275,067,776.4	361,337,963.4	86,270,187.0
Барилга, байгууламж, орон сууц	164,768,405.8	231,190,175.3	66,421,769.5
Авто-тээврийн хэрэгсэл	3,670,378.5	4,346,253.4	675,874.9
Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,258,775.0	118,299,556.2	18,040,781.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	5,856,476.8	6,942,858.2	1,086,381.4
Бусад үндсэн хөрөнгө	456,756.2	502,136.2	45,380.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	6,647.5	6,647.5	-
Ном	50,336.6	50,336.6	-
Биет бус хөрөнгө	10,319,433.5	9,747,062.1	(572,371.5)
Программ хангамж	2,960,917.7	1,989,154.9	(971,762.9)
Биет бус хөрөнгө	7,358,515.8	7,757,907.2	399,391.4
Дүн	285,387,210.0	371,085,025.5	85,697,815.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үндсэн хөрөнгийн данс тайлант онд 2,027.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 124,112.6 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 3,934.5 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр нэмэгдэж, 3,393.1 сая төгрөгийн хөрөнгө акталж, 2,546.3 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлж, 12,377.4 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол болон тайлант үеийн элэгдлийн зардал 26,059.9 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны өсөлтөд барилга байгууламж дансанд “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт төсөл, Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл, Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслүүдийн хүрээнд бий болсон нийт 72,309.5 сая төгрөгийн хөрөнгийг ГЕГ-ын даргын А/388, А/389, А/606, А608 тушаалуудаар, машин тоног төхөөрөмж дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”, “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-үүдийн хүрээнд бий болсон нийт 44,142.2 сая төгрөгийн хөрөнгийг ГЕГ-ын даргын А/33, А293, А/294, А/323, А/324, А/325, А/433, А434, А/486 тушаалуудаар бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны А-1/1883 тоот албан бичгийн дагуу 5 нэр төрлийн 522.5 сая төгрөгийн балансын үнэтэй 8 тээврийн хэрэгслийн үнийг нийт 299.0 сая төгрөгөөр бууруулан, 223.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын илрүүлэлт:

- Газар эзэмших эрхийн гэрчилгээгээр 1,151 м.кв болон 1,168 м.кв талбайтай 2 гэрчилгээтэй газруудыг санхүүгийн тайланд 2,321 м.кв талбайтай 1 газар гэж тусгасан. /Улаанбаатар хот дахь ГГ/
- Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй. /Ханги дахь ГГ/
- Биет тооллого явуулахад бүртгээгүй хөрөнгө илрүүлсэн. /Ханги дахь ГГ/
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1,352.0 сая төгрөгийн 1217 ширхэг хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй. /ГЕГ-ын Үйлчилгээ аж ахуйн алба/

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 4,016.5 сая төгрөг болж, өмнөх оноос 7,954.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон өглөг	-	84.4	84.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг	30.6	182,655.3	182,624.7
Байгууллагад төлөх өглөг	11,970,741.1	3,832,466.8	(8,138,274.2)
Хувь хүмүүст өгөх өглөг	346.4	1,294.1	947.7
Дүн	11,971,118.1	4,016,500.7	(7,954,617.4)

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Өр төлбөрийн үлдэгдэл өмнөх оноос нийт 7,954.6 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад төлөх өглөг 8,138.3 сая төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

Сангийн сайдын 2024 оны 224 дүгээр тушаалаар Гаалийн ерөнхий газрын давсан орлогоос 709.9 сая төгрөгийг зарцуулах эрх олгогдсоны дагуу 2025 онд ерөнхий гэрээний дагуу Бодь Электроникс ХХК-тай байгуулсан ГЕГ/021/001 гэрээний төлбөр 448.3 сая төгрөг, Нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарсан МСМ групп ХХК-тай байгуулсан ГЕГ/20250102042/01/01 дугаартай гэрээний төлбөр 256.0 сая төгрөг, Үйлчилгээ аж ахуйн албаны 3 аж ахуйн нэгжтэй байгуулсан 1,163.1 сая төгрөгийн гэрээний гүйцэтгэл санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг ГЕГ-ын даргын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/4319 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн боловч зарцуулах эрх нээгдээгүйгээс байгууллагад төлөх өглөг үүссэн, Ханги дахь гаалийн газар 984.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл бүртгэсэн байна.

Мөн 13 аж ахуйн нэгжийн чанарын баталгааны барьцаа төлбөр 584.2 сая төгрөгийн байгууллагад өгөх өглөг барьцаа дансанд бүртгэлтэй байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 386,062.4 сая төгрөг болж, өмнөх оноос 72,833.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	72,665,451.2	72,833,827.2	168,376.0
Хуримтлагдсан үр дүн	233,781,519.9	306,507,846.5	72,726,326.6
Өмнөх үеийн үр дүн	115,895,591.2	233,787,618.5	233,787,618.5
Тайлант үеийн үр дүн	117,885,928.7	72,720,228.0	72,720,228.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,781,682.1	6,720,751.8	(60,930.3)
Дүн	313,228,653.2	386,062,425.5	(72,833,772.3)

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Засгийн газрын хувь оролцоо данс нь Гаалийн ерөнхий газрын үйлчилгээ аж ахуйн алба нь ГЕГ, Гаалийн төв лабораторийн байршиж байгаа 5200 м.кв газрыг ТӨБЗГ-ын 2024.12.30-ны өдрийн А1/2472 тоот албан бичиг, ГЕГ-ын даргын 2025.01.31-ний өдрийн А/28 тоот тушаалаар бүртгэсэн 168.4 сая төгрөг, тайлант үеийн үр дүнгийн 72,720.2 сая төгрөгөөр нэмэгдэж, нягтлан бодох бодлогын өөрчлөлтийн 54.8 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Гаалийн ерөнхий газар нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 150,514.1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4,390.7 сая төгрөг, нийт 154,904.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 7,204.5 сая төгрөгөөр бууруулж, 147,700.3 сая төгрөгөөр баталсан байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Гаалийн ерөнхий газрын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 7,777,800.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 6,646.9 сая төгрөг, нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 4,147.8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 3,030.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,598.8 сая төгрөг, бусад зардлыг 1,279.7 сая төгрөгөөр тус тус бууруулж, Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэх урсгал зардлын эх үүсвэрийг нийт 130,997.1 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 110,168.0 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 3,333.2 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 9. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	7,777,800,000.0	6,712,800,000.0	(1,065,000,000.0)	86.3
Нийт дүн	7,777,800,000.0	6,712,800,000.0	(1,065,000,000.0)	86.3

Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Гаалийн байгууллага нь 7,777,800.0 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 6,712,800.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 86.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унасан нь уул уурхайн салбарын өсөлтийг сааруулсан, үүний улмаас эдийн засгийн идэвхжил суларч, импорт буурснаас шалтгаалсан байна.

Бодлогын арга хэмжээ: Нүүрсний үнийн уналтаас үүдэлтэй гадаад валютын нөөцийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авсан:

Хүснэгт 10. Туслах үйл ажиллагааны орлого /мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	4,390,707.2	3,333,254.2	1,057,453.0	75.9
Нийт дүн	4,390,707.2	3,333,254.2	1,057,453.0	75.9

Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний биелэлт 75.9 хувь буюу 1,057.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 120,563.1 сая төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 18,854.4 сая төгрөг, харуул хамгаалалтын зардлыг 128.2 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 130.1 сая төгрөг, нүүлгэн шилжүүлэх зардлыг 210.0 сая төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг 85.4 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70205	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	139,982,337.6	120,563,137.0	19,419,200.6	86.1
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	123,956,210.7	105,101,814.4	(18,854,396.3)	86.5
80103	Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	726,988.1	641,590.6	(85,397.5)	85.1
80219	Харуул, хамгаалалтын зардал	867,562.5	739,354.1	(128,208.4)	88.3
80220	Холбооны суваг ашигласны хөлс	869,368.8	859,181.5	(10,187.3)	85.2
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд дэмжлэг	3,271,089.1	3,140,973.0	(130,116.1)	98.8
80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	120,088.7	119,193.7	(895.0)	96.0
80811	Нүүлгэн шилжүүлэх зардал	210,000.0	-	(210,000.0)	99.3
80819	Хөрөнгө оруулалт	9,961,029.7	9,961,029.7	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүд нь зохион байгуулалтын бүтцийн нэгж, албан тушаалтныг цомхотгож ажилласан байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 271.1 дүгээр зүйлийн 271.1.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх хэсэг, Захиргааны зөвлөлийн ээлжит бус 1 дүгээр хуралдааны 2024

оны 02/02 дугаар шийдвэрийн дагуу алба хаагчдын хоол, унааны мөнгийг олгож байна. Үүнд:

- Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллага, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар хоолны мөнгөнд 29,500.00 төгрөг, бусад газар, хороо 25,000.00 төгрөг,
- Гаалийн ерөнхий газар болон дэргэдэх байгууллага, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар 500.00 төгрөг, бусад газар, хороо унааны мөнгө олгохгүй байна.

Тайлант онд тус Гаалийн ерөнхий газрын даргын харьяа байгууллагуудын хэмжээнд 139.8 сая төгрөгийн 58 хурал цуглаан зохион байгуулах арга хэмжээ төлөвлөснөөс 65.7 сая төгрөгийн 16 хурал, зөвлөгөөн зохион байгуулсан байна.

Сангийн сайдын №46 тоот тушаал, ГЕГ-ын даргын А/55, А/60, А/245, А/269, А/341, А/416, А/448 тоот тушаал, ГЕГ-ын даргын баталсан төсөв, удирдамжийн дагуу тайлант онд 7 арга хэмжээний дагуу гадаад томилолтоор ажилласан байна

Гаалийн ерөнхий газар нь хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг 2 аж ахуй нэгжтэй 19.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжилтийг олгосон байна.

Гаалийн ерөнхий газрын хэмжээнд үйл ажиллагаанд ашиглаж байгаа 1,040.5 сая төгрөгийн 6 төрлийн программ хангамж бүртгэлтэй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нийт 1,594.3 сая төгрөгийн нэмэлт орлогын эх үүсвэрийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- **Төсвийн жилийн давсан орлогоос хуваарилсан 710.0 сая төгрөг.** Үүнд: Сангийн 2024 оны 224 дүгээр тушаалаар олгосон 710.0 сая төгрөгийн зарцуулах эрх нээгдээгүйгээс буцаан татуулж, татаас санхүүжилтийн авлагаар тооцоо нийлсэн;
- **Хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 52.1 сая төгрөг.** Үүнд: Замын-Үүд боомтын бүтээн байгуулалтын хүрээнд Гарден сити ХХК-иас 20.0 сая төгрөг, Увс аймгийн ЗДТГ-аас 14.0 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн ИТХ-аас 13.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-аас 3.5 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Бургастай дахь Ард даатгал ХХК-иас автомашины даатгалын нөхөн төлбөрт 1.6 сая төгрөг.
- **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах арга хэмжээнд нийт 53.7 сая төгрөг.** Үүнд: Орхон аймгийн ГГ-т 29.5 сая төгрөг, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь ГГ 24.2 сая төгрөг.
- **Төрийн үйлчилгээний албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл 714.2 сая төгрөг.** Үүнд: Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар төрийн үйлчилгээний албан хаагчдад 399.9 сая төгрөг, Өмнөговь аймгийн харьяалалтай алба хаагчдад 246.9 сая төгрөг, Дархан-Уул аймгийн ИТХ-ын тогтоолоор 38.9 сая төгрөг, Орхон аймгийн албан хаагчдад 28.5 сая төгрөг.
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгээр санхүүжүүлэх “Хилийн нэвтрэх цэгт нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ авах, үйл явдлыг илэрхийлэх, эрт сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд стратегийн эрсдэлийн үнэлгээ хийх” ажилд 64.3 сая төгрөг.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардалд 709.3 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 3.3 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 10.3 сая төгрөг, томилолт, зочны зардалд 67.9 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 6.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2.6 сая төгрөгийг тус тус зарцуулж, 739.5 сая төгрөгийн үлдэгдлийг Сангийн яамтай тооцоо нийлж, татаас санхүүжилтийн авлагаар тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6 Худалдан авах, ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээгээр 959.0 сая төгрөгийн 5, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 19,630.6 сая төгрөгийн 45, харьцуулалтын аргаар 1,845.7 сая төгрөгийн 35, шууд худалдан авалтын аргаар 1,798.2 сая төгрөгийн 143, нийт 24,040.4 сая төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахаар тусгасан байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11,270.0 сая төгрөг;
- Урсгал төсвөөс 12,770.4 сая төгрөг.

Гүйцэтгэлээр ерөнхий гэрээгээр 508.1 сая төгрөгийн 4 худалдан авалт, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 16,640.0 төгрөгийн 38 худалдан авалт, харьцуулалтын аргаар 1,659.3 сая төгрөгийн 33 худалдан авалт, шууд худалдан авалтын аргаар 1,775.9 сая төгрөгийн бараа, ажил, нийт 20,075.2 сая төгрөгийн хөрөнгө, бараа, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гаалийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, орлогын төлөвлөлт, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитор Б.Тэгшсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Гаалийн ерөнхий газар 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/948 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 154,186.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,541.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуваарилагдсан төсвийг үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулах, хуульд тусгагдсан хэмнэлтийн горим, бусад арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоход анхаарч ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгосон. Дархан-Уул аймаг дахь ГГ
- Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, олон нийттэй харилцах албаны чиг үүргийг давхардуулан мониторингийн үйлчилгээг гадны байгууллагатай 19.3 сая төгрөгийн гэрээ байгуулж, 12.3 сая төгрөгийг зарцуулсан. Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс ГЕГ

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд гаалийн байгууллагын хэмжээнд шилэн дансанд байршуулах нийт мэдээллээс 4 мэдээлэл байршуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны цахим системд 4 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй./ Улс хоорондын шуудан илгээмжийн ГГ/

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харьяа байгууллагуудын аудитаар бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 167.7 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэнд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүн 264.3 сая төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 96.6 сая төгрөгөөр тусгагдаж 167.7 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн. /Улс хоорондын шуудан илгээмжийн ГГ/
- Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/272 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт нь шинээр баталсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжтой нийцээгүй. /Шивээхүрэн дэх ГГ/
- Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/272 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт нь шинээр баталсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомжтой нийцээгүй. /Гашуунсухайт дахь ГГ/

4.4.2.2 Түүврийн байгууллага

Илрүүлэлт: Гаалийн улсын байцаагч нарын хэрэглэх дүрэмт хувцас, ялгах тэмдэг нь эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэр, батлагдсан стандарт, нормгүй байгаагаас дүрэмт хувцасны үнийн тариф, зардлыг тодорхойлох боломжгүй, өндөр үнэтэй худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дүрэмт хувцас, ялгах тэмдгийн норм, стандарт, үнийн жишгийг батлуулж, худалдан авалтыг үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлэх

Илрүүлэлт: Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд 15 тээврийн хэрэгсэл бүртгэлтэйгээс 3 тээврийн хэрэгсэл гаалийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдахгүй байгаа тээврийн хэрэгслийн хэрэгцээ, зориулалтыг дахин үнэлж, цаашид ашиглах, шилжүүлэх талаар арга хэмжээг авч ажиллах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн харьяа Гаалийн газар, хороодын аудитаар илэрсэн дээрх асуудлууд хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө болон зардлын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулж, залруулагдах боломжгүй 12.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, зөрчлийг таслан зогсоох 67.2 сая төгрөгийн 2 албан шаардлага, зөрчлийн давтан гаргахгүй байх 709.9 сая төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэхэд 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 11. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төсвийн төвлөрүүлэн захирагч					
Хариуцлага тооцох албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
Төсвийн шууд захирагч					
Зөвлөмж	3	709,950.0	3	709,950.0	100.0
Албан шаардлага	2	67,191.7	2	67,191.7	100.0
Нийт дүн	7	777,141.7	7	777,141.7	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны төсөвт тусган худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан боловч гүйцэтгэлээр 966.3 сая төгрөгийн зардлын эх үүсвэргүй, төлөгдөөгүй өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүнээс шалтгаалж дараа жилийн төсөвт төлөвлөгдөөгүй зардал гарах, төлөвлөгдсөн ажлын санхүүжилт хүрэлцэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн, мөнгөн хөрөнгийн зохистой удирдлага алдагдах эрсдэлтэй байгаа тул дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,055.7 сая төгрөгийн 31 алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,055.7 сая төгрөгийн 30 алдааг залруулж, 1 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 124.5 сая төгрөгийн 20 зөрчил² илэрсэнд 18.1 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 28.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 77.5 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 124.5 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,417.4 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгсөн.

5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 17 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 17 байгууллагад /Өөрчлөлтгүй/ дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан. “Горхи, мэлхий хад” амралтын газар үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар аудитад хамрагдаагүй.

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 1,583.3 сая төгрөгийн 28 алдааг залруулж, залруулагдаагүй 1 алдаанд зөвлөмж, 8.2 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 443.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 239.9 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

5.3 Түүврийн байгууллага

Аудитаар нийт 464.2 сая төгрөгийн 1 алдаа илэрснээс аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Гаалийн ерөнхий газрын Аж ахуй, үйлчилгээний алба нь санхүүгийн тайланд 759.8 сая төгрөгийн лицензийн төлбөрийн дараа онд ногдох нийт 464.2 сая төгрөгийн зардлыг хуваарилж бүртгээгүй, шууд зардлаар тайлагнасан байна.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг”, санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй дээрх алдааг аудитын явцад бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 81.5 сая төгрөгийн 5 зөрчил илэрсэнд 10 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 12.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 59.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

5.3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Хөвсгөл аймгийн гаалийн хэлтсийн 8 айлын орон сууц барилгын ажлыг 2014 онд гүйцэтгүүлэх гэрээг Сант өндөр ХХК-тай байгуулж 10.0 сая төгрөгийн барьцаа байршуулсан, тайлант онд харилцагч талаас нэхэмжлэх шаардлагагүй гэсэн тооцоо ирүүлсэн боловч тус барьцааны үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-д “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.", 42.9-т "Гүйцэтгэгч энэ хуулийн 42.8-д заасан гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөнд тооцож, гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн орлого болгоно.", Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.2-т "Барьцааны эрх үүссэнээр тухайн этгээд үүргийн гүйцэтгэлийг шаардах давуу эрх эдэлнэ.", 234 дүгээр зүйлийн 234.4-т "Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардана.", Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д "төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэхэмжлэх шаардлагагүй болсон Хөвсгөл аймгийн гаалийн хэлтсийн 8 айлын орон сууц барилгын ажлын барьцааны үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.3.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс олон нийттэй харилцах албаны чиг үүргийг давхардуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээнд мониторингийн үйлчилгээ хийлгэж, жил бүр Энх-Арслан ХХК-тай 19.3 сая төгрөгийн гэрээ байгуулж, тайлант хугацаанд 12.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулаагүй, олон нийттэй харилцах албаны чиг үүргийг давхардуулан бусад байгууллагаар хэвлэл мэдээллийн мониторинг хийлгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийг үр ашигтай зарцуулах

Илрүүлэлт: Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй Монгол бичгийн хаяг хийлгэхэд 14.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөвт тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх

Илрүүлэлт 2: Тайлант онд ажил байдлын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаа албан хаагч нарын илүү цагийн хөлсөнд нийт 45.1 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 91-р зүйлийн 91.2-т "Дараах тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулж болно", 91.2.4-т "урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай гүйцэтгэхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадаас урьдчилан сэргийлэх, эсхүл учирсан саадыг арилгахад чиглэгдсэн хойшлуулшгүй ажил гүйцэтгэх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Чиг үүргийн бус нэмэлт ажил, үүрэг гүйцэтгэх үед илүү цагаар ажилласан тохиолдолд тухайн ажлыг гүйцэтгэх талаар гарсан шийдвэр, ажлын тайлан болон холбогдох бусад баримт бичгийг үндэслэн шийдвэрлэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гашуунсухайт дахь ГГ	1	-							1	-	1	-
Говь-Алтай аймгийн Бургастай дахь ГХ	1	731.0			1	731.0	1	731.0				
Дархан-Уул аймаг дахь ГГ	3	120,955.7	2	113,455.5	1	7,500.2	3	120,955.7				
Дорнод аймаг дахь ГГ	1	1,081.1			1	1,081.10	1	1,081.1				
Орхон аймаг дахь ГГ	1	16,949.9	1	16,949.9			1	16,949.9				
Сайншанд дахь ГГ	4	525,503.8	2	482,782.9	2	42,720.9	4	525,503.8				
Увс аймаг дахь ГГ	3	446,697.8	2	437,997.8	1	8,700.0	3	446,697.8				
УБ хот дахь ГГ	3	106,855.2	1	19,988.9	2	86,866.3	3	106,855.2				
УХШИГГ	3	293,941.1	1	1,062.3	2	292,878.8	3	293,941.1				
Ханги дахь ГГ	2	4,629.3	-	-	2	4,629.3	2	4,629.3				
Ханх дахь ГГ	2	54,107.0	1	11,605.4	1	42,501.6	2	54,107.00				
Шивээхүрэн гаалийн газар	3	5,742.0	-	-	3	5,742.0	3	5,742.0				
Чингис хаан ОУ-ын нисэх буудлын ГГ	1	6,104.9			1	6,104.9	1	6,104.9				
Харьяа байгууллагын дүн	28	1,583,298.8	10	1,083,842.7	17	499,456.1	27	1,583,298.8	1	-	1	-
Түүврийн байгууллага												
Аж ахуй, үйлчилгээний алба	1	464,173.5			1	464,173.5	1	464,173.5				
Замын-Үүд дахь ГГ	2	8,211.3	1	1,162.4	1	7,048.9	2	8,211.3				
Нийт дүн	31	2,055,683.6	11	1,085,005.1	19	970,678.5	30	2,055,683.6	1	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гашуунсухайт дахь ГГ	1	-					1	-				
Дархан-Уул аймаг дахь ГГ	1	3,564.0					1	3,564.0				
Дорнод аймаг дахь ГГ	3	7,602.9	1	294.60	1	7,308.3	1	-				
Завхан аймаг дахь ГГ	2	10,201.8	1	7,861.8			1	2,340.0				
Орхон аймаг дахь ГГ	2	9,443.7	-	-	1	9,316.2	1	127.5				
Сэлэнгэ аймаг дахь ГГ	1	11,518.2					1	11,518.2				
Уб хот дахь ГГ	1	-					1	-				
Шивээхүрэн дэх ГГ	2	735.4					2	735.4				
Ханги аймаг дахь ГГ	2	-					2	-				
Харьяа байгууллагын дүн	15	43,066.0	2	8,156.4	2	16,624.5	11	18,285.10				
Түүврийн байгууллага												
Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	2	22,250.0	1	10,000.0	1	12,250.0						
Аж ахуй, үйлчилгээний алба	3	59,217.0	-	-	-	-	3	59,217.0				
Нийт дүн	20	124,533.0	3	18,156.4	3	28,874.5	14	77,502.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар	1	426,478.0			1	426,478.0		
Дүн	1	426,478.0			1	426,478.0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар	1	167,718.3					1	167,718.3
Дүн	1	167,718.3					1	167,718.3
Харьяа байгууллагуудын дүн	2	594,196.3			1	426,478.0	1	167,718.3
Түүврийн байгууллага								
Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	1	-					1	-
Аж ахуй, үйлчилгээний алба	1	-					1	-
Нийт дүн	4	594,196.3			1	426,478.0	3	167,718.3



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 211/СО111333

Улаанбаатар хот

САГ-2026/3/КА-СТА-ТТЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн гаалийн хэлтсийн 8 айлын орон сууцны барилгын ажлыг 2014 онд гүйцэтгүүлэх гэрээг Сант өндөр ХХК-тай байгуулж 10,000,000.00 /Арван сая/ төгрөгийн барьцаа байршуулсан, тайлант онд харилцагч талаас нэхэмжлэх шаардлагагүй гэсэн тооцоо ирүүлсэн боловч тус барьцааны үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-д "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.", 42.9-т "Гүйцэтгэгч энэ хуулийн 42.8-д заасан гүйцэтгэлийн баталгааг шинэчлэн хүргүүлэх үүргээ гүйцэтгээгүй бол түүнийг гэрээний үүргээ зөрчсөнд тооцож, гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн орлого болгоно.", Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.2-т "Барьцааны эрх үүссэнээр тухайн этгээд үүргийн гүйцэтгэлийг шаардах давуу эрх эдэлнэ.", 234 дүгээр зүйлийн 234.4-т "Үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй бол үүрэг гүйцэтгүүлэгч үүргийн гүйцэтгэлийг баталгаа гаргагчаас үл маргах журмаар шаардана.", Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д "төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.7-д "төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэхэмжлэх шаардлагагүй болсон Хөвсгөл аймгийн гаалийн хэлтсийн 8 айлын орон сууцны барилгын ажлын барьцааны үлдэгдлийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Гаалийн ерөнхий газрын дарга (П.Дэлгэрнаран), Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Долгорсүрэн) нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Б.ТЭГШСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1147/СО111333

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА-СТА-ТТЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гаалийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс олон нийттэй харилцах албаны чиг үүргийг давхардуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээнд мониторингийн үйлчилгээ хийлгэж, жил бүр Энх-Арслан ХХК-тай 19,250,000.00 /Арван есөн сая хоёр зуун тавин мянган/ төгрөгийн гэрээ байгуулж, тайлант хугацаанд 12,250,000.00 /Арван хоёр сая хоёр зуун тавин мянган/ төгрөгийг зарцуулсан байна.


Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх", 15 дугаар зүйлийн 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулаагүй, олон нийттэй харилцах албаны чиг үүргийг давхардуулан бусад байгууллагаар хэвлэл мэдээллийн мониторинг хийлгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дарга (П.Дэлгэрнарэн), Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Долгорсүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Ж.НЯМЦЭЦЭГ
Б.ТЭГШСҮРЭН